

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
П.СҮХБААТАРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ болон хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд хилийн хорио цээрийн хяналтын чиг үүргийг нэмж, холбогдох судалгаа, тайлбар хийж шинэчлэн боловсруулсан байна.	“Ажлын хэсэг байгуулах тухай” ГЕГ-ын даргын 2023 оны №А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд орж ажилласан. Энэ хугацаанд 2021-2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн. Мөн гаалийн байгууллагын чиг үүрэгт шинээр орсон хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын асуудлыг шинээр бүлэг болгон Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Түүнчлэн гадаад улсуудын жишиг, УИХ-ын гишүүдтэй хийсэн уулзалт дээр өгсөн чиглэлийн дагуу Гаалийн тариф,	01.01-12.08	100

				гаалийн татварын тухай хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлд нэгтгэн найруулав. Гаалийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн найруулсан. ДГБ-ын багц стандарт, гарын авлага, бусад орны хууль тогтоомжуудыг судалж, Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенци /Киото контенци/ болон түүнд оруулах өөрчлөлтүүд, ДГБ-аас өгсөн зөвлөмжүүдтэй танилцсан. Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, гаалийн газар хороодоос ирсэн саналуудтай нэгбүрчлэн танилцаж, ирсэн саналуудыг бүлэглэн хуулийн төслийн холбогдох хэсгүүдэд тусган, хүлээн авах боломжгүй саналуудын шалтгааныг тэмдэглэн ажиллав. Хуулийн төслийн холбогдох заалтуудыг боловсруулах үед ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, гарч буй хүндрэл, хуулиар зохицуулах шаардлагатай байгаа асуудлууд, худалдаа хөнгөвчлөх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар ярилцаж саналуудыг тусган ажилласан болно. I хэсэг.Ерөнхий зүйл Хуулийн зорилго, томъёоны тодорхойлолт хэсэгт буюу I-IV бүлэгт хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой асуудлыг нэмж тусгасан. II хэсэг.Мэдээлэл, зөвлөгөө лавлагаа, гомдол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Захиргааны ерөнхий хууль, ДХБ-ын ХХХ-т заасан “Хэвлэл нийтлэл болон мэдээллийн хүртээмж”, “Цахим төлбөр”, “Гомдол гаргах болон гомдлыг хянан шалгах ажиллагаа”, Гаалийн бүрдүүлэлтийн горимыг уялдуулах, хялбарчлах тухай конвенцийн “Мэдээлэл технологи ашиглах”, Статистикийн тухай хууль, Нууцын тухай		
--	--	--	--	---	--	--

				хууль, Хүний хувийн мэдээлийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг судалсан. Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, гаалийн статистик, мэдээллийн технологи ашиглахтай холбогдсон харилцааг Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Мэдээллийн технологийн газраас ирүүлсэн санал, холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай уялдуулан боловсруулсан. III хэсэг.Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, чөлөөлөх Гаалийн тарифын тогтолцоо, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн тарифын зөвлөл, гаалийн үнэ, барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, урьдчилсан шийдвэр, гаалийн болон бусад татвар ногдуулах, төлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг тусгана. урьдчилсан шийдвэр, барааны ангилал, гаалийн үнэлгээний асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд гаалийн болон бусад татварыг төлөх баталгаа, эсхүл татварыг холбогдох дансанд байршуулан барааг олгох болон татвар, тарифтай итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гаалийн болон бусад татвар төлөх хугацааг уян хатан болгохтой холбогдсон бусад харилцааг нарийвчлан тусгасан. IY хэсэг.Гаалийн хяналт, бүрдүүлэлт Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн II-X бүлэг буюу 28-186 зүйлд гаалийн хяналт, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх, барааг мэдүүлэх, зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх онцлог, гаалийн шалгалттай холбоотой үйл ажиллагааг тусгасан. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн хяналт, шалгалттай холбоотой асуудлыг хуулийн төсөлд нэг бүлэг болгон нэмж тусган, хорио цээрийн хяналтын ангилал, хамрагдах бараа,		
--	--	--	--	---	--	--

				тавигдах нийтлэг шаардлага, хорио цээрийн үзлэг, халдваргүйжүүлэлт, барааг буцаах зэрэг зохицуулалтуудыг ажлын хэсгийн гишүүд болон Хорио цээрийн хэлтэстэй хамтран боловсруулсан. Гаалийн мэдүүлэг, түүний төрөл, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх, урьдчилан мэдүүлэх, мэдүүлэх хугацаа, мэдүүлэгчийн эрх, үүрэг, барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт, гаалийн мэдүүлэгт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хорио цээрийн хяналттай уялдуулан боловсруулсан. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдлийн мэдээлийн сан, эрсдэл тооцох үйл ажиллагааг тодорхой болгож, хорио цээрийн эрсдэлийн удирдагыг гаалийн эрсдэлийн удирдлагатай уялдуулан найруулсан болно. Гаалийн хяналтад орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, гаалийн тэмдэглэгээ хийхэд ухаалаг ломбо ашиглах заалт, гаалийн магадлан шинжилгээнд ирүүлэх барааны тоо тэмжээг тогтоох заалт нэмж оруулсан. Гаалийн итгэмжлэгдсэн операторын зохицуулалтыг шинээр оруулсан. Зөвшөөрлийн тухай хуульд Гаалийн түр агуулах ажиллуулах үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан тул хуульд нийцүүлэн нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан. Гаалийн хяналтын бүс тогтоох, сунгах, түдгэлзүүлэх, татан буулгах, Гаалийн тээвэрлэгчээр бүртгэх үйл ажиллагааг цахимд шилжүүлсэнтэй холбоотой тавигдах нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг бусад зөвшөөрөлтэй уялдуулсан.		
--	--	--	--	---	--	--

				Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбогдсон харилцааг тодорхой тусгаж, шалгалтын төрөлтэй холбоотой хэсгийг өөрчлөн найруулж, гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар гаалийн байгууллагад барааг мэдүүлээгүй, өөр бараагаар, эсхүл дутуу мэдүүлсэн зэрэг зөрчилд шийтгэл ногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш барааг гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийлгэх, бусад зөрчилд шийтгэлийн хуудсаар шийдвэрлэхээр төсөлд тусгав. V хэсэг.Гаалийн бүрдүүлэлтийн горим Гаалийн тухай хуулийн шинчилсэн найруулгын төслийн 189-307 дугаар зүйлд Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал, төрөл, тэдгээрийг сонгох, барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, гаалийн болон бусад татвар төлөх үүрэг үүсэх, гаалийн болон бусад татвар ногдуулах, тарифын бус хязгаарлалт, горимд байршуулахаас татгалзах, эрх шилжүүлэх, бараа, тээврийн хэрэгслийг буцаан гаргах, буцаан оруулах, гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох, гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын кодтой холбогдсон харилцааг дахин хянаж, зарим зүйл, хэсэгт найруулгын өөрчлөлт оруулсан. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон г захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглосон тул гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг тодорхой тусгасан, гаалийн баталгаат агуулахад тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлсон. Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг сонон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор зохицуулсан байсан боловч УИХ-аас 2023.01.06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт баталсан Гаалийн тухай хуульд нэмэл оруулах тухай хуулийг судалж үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт,		
--	--	--	--	--	--	--

					өөрчлөлт оруулах тухай хуулиар Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгохоор зохицуулсан. Гэвч 2023.01.06-ны өдөр батлагдсан Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 139.1.17.заалт нэмж, татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд бүрдүүлэх бичиг баримтыг тогтоосон байна. Дээрх 2 хуульд зарчмын зөрүүтэй зохицуулалт орсон тул татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох асуудлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор төсөлд найруулж, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барихаар боловсруулсан болно. VI хэсэг.Гаалийн албаны тогтолцоо Гаалийн албаны тодорхойлолт, тогтолцоо, удирдлага, санхүүжилт, түүний үйл ажиллагааны зарчим, гаалийн байгууллага, түүний удирдлага, алба хаагчийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон. Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн болно.		
1	Арга хэмжээ №1.1. ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний	Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2022 оны 55 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолыг удирдлага болгон Гаалийн ерөнхий газрын даргын хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд баталсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хийж гүйцэтгэн 17 хуудас	01.01-12.08	100

	захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шаардлага тай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцон			дүгнэлтэд үндэслэн шаардлагатай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцоно.	бүхий хавсралтыг ГЕГ-ын даргын 2024.09.26-ны өдрийн №01/3943 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 1.ГЕГ,ОӨГ-ын даргын нарын 2009.06.18-ны өдрийн Журам батлах тухай 298/41 хамтарсан тушаалаар батлагдсан “Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 262 дугаар зүйлд Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын болон Оюуны өмчийн газрын дарга нар хамтран батална гэж заасан. Санал: -Хамтарсан тушаал 2.ГЕГ-ын даргын 2013.09.26-ны өдрийн Үйлчилгээний хураамжийн хэмжээ тогтоох тухай А/199 дугаар тушаалаар батлагдсан журам, хоёр хавсралттай. Нэгдүгээр хавсралтаар “Үйлчилгээний хураамжийн хэмжээ”, хоёрдугаар хавсралтаар “Гаалийн төв болон салбар лабораторийн шинжилгээний хураамжийн хэмжээ”-г тогтоосон. Захиргааны хэм хэмжээний акт батлах ,эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 26 дугаар зүйлд Гаалийн бүрдүүлэлтийн хураамж гэж, 26.1-д Мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж төлнө, 26.2-т энэ хуулийн 26.1-д заасан хураамжийн хэмжээг үйлчилгээний зардлыг харгалзан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно гэж заасан. /тушаал дээр Хууль зүйн яамны 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 2/2334 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг үндэслэсэн/ Санал: -Хэвээр үлдээх саналтай бөгөөд үндэслэлийн хувьд гаалийн бүрдүүлэлт хийх болон лабораторийн дүгнэлт		
--	---	--	--	---	---	--	--

				гаргахад гарч байгаа тодорхой зардлыг үйлчлүүлэгчээс гаргуулан улсын төсөвт төвлөрүүлэх. 3. ГЕГ-ын даргын 2016.11.29-ний өдрийн Заавар батлах тухай А/62 дугаар тушаалаар батлагдсан “Бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах заавар”. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйл Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл, 232.2 Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах бөгөөд зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан тусгай журам тогтоож болно гэж заасан. Санал: - Хүчингүй болгох боломжтой буюу бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах зааврыг тусад журамлах шаардлагагүй гэж үзэж байгаа бөгөөд Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу ангиллын кодыг тодорхойлж ангилах боломжтой. Эсхүл ГЕГ-ын даргын 2008.10.15-ны өдрийн Журам батлах тухай 362 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-д нэгтгэх саналтай байна. 4.ГЕГ-ын даргын 2016.12.12-ны өдрийн Журам батлах тухай А/79 дугаар тушаалаар батлагдсан “ТИР конвенцийг хэрэгжүүлэх, ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих журам”. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйл Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл, 232.2 Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга		
--	--	--	--	---	--	--

				батлах бөгөөд зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан тусгай журам тогтоож болно гэж заасан. Санал: -Хүчингүй болгох саналтай бөгөөд заавал тусад нь журамлах шаардлагагүй “Тир карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц”-иор зохицуулах боломжтой. 5.ГЕГ-ын даргын 2016.12.12-ны өдрийн Журам батлах тухай А/80 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтрүүлэх цахилгаан эрчим хүчинд гаалийн хяналт тавих, бүрдүүлэлт хийх журам”. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 24 дүгээр зүйл Гаалийн бүрдүүлэлт хийх, 24.3 Гаалийн хилээр нэвтрүүлэх зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан гаалийн бүрдүүлэлтийн журмыг энэ хуульд нийцүүлэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тусгайлан баталж болно гэж заасан. Санал: -Хүчингүй болгох саналтай бөгөөд хууль эрх зүйн үндэслэлийн хувьд ГЕГ-ын даргын 2008.10.15-ны өдрийн Журам батлах тухай 362 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-д нэгтгэх саналтай байна. 6. ГЕГ-ын даргын 2016.12.12-ны өдрийн Журам батлах тухай А/81 дугаар тушаалаар батлагдсан “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис тэдгээрийн түүхий эдийг МУ-ын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих тусгай журам”. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйл Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, 6.6 Мансууруулах эм,		
--	--	--	--	--	--	--

					сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журмыг гаалийн удирдах төв байгууллага баталж мөрдүүлнэ гэж заасан. Санал: -Хэвээр үлдээх саналтай 7.ГЕГ-ын даргын 2016.12.12-ны өдрийн Заавар батлах тухай А/82 дугаар тушаал. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн Үндсэн маягтыг 1 дүгээр, Нэмэлт маягтыг 2 дугаар, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн хавсралт”-ыг 3 дугаар, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ыг 4 дүгээр, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсан. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйл Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх, 55.5 Гаалийн мэдүүлгийн маягтын загвар, түүнийг нөхөн бичих, шалгах зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална гэж заасан. Санал: - Хэвээр үлдээх саналтай бөгөөд үндэслэлийн хувьд бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх анхан шатны баримт нь гаалийн мэдүүлэг учир.		
1	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ГЕГ-аас батлан гаргах захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын төслийн хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд	Тайлант хугацаанд ГЕГ-аас батлан гаргах дараах эрх зүйн актын төслийг хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгч ажилласан. Үүнд: 1. “Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Монголын бизнес консалтинг (МВС) компанийн хооронд хамтран ажиллах санамж бичиг”-ийн төсөл 2. “Зарим төрийн тусгай албан тушаалд иргэнийг томилоход тавигдах шаардлага болон гаалийн улсын	01.01-12.08	100

	тавьсан байдал			хяналт тавьж, санал өгсөн байх, байцаагчаар томилох иргэнд тавигдах шаардлага"-ын төсөл, 3. Боршоо-Хандгайт боомтын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал бүхий ноот бичгийн төсөл, 4. Гаалийн ерөнхий газар болон “Арш Технологи” ХХК-ийн хооронд хийсэн худалдах, худалдан авах гэрээ, 5. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл 6. “Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тушаалын төсөл 7. Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журам”-ын төсөл, 8. “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын төсөл, 9. “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын төсөл, Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ		
2	Хууль, хяналтын байгууллаг ад Гаалийн байгууллаг ыг төлөөлөх, хамтран	Хэрэгжил т, гүйцэтгэл ээр		Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн үндсэн дээр Тайлант хугацаанд нийт 4 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гаалийн ерөнхий газрыг хохирогчоор тогтоосон байх тул ГЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, мэдүүлэг өгөх зэргээр ажилласан. Үүнд: 1. АТГ-ын 2024 оны 02 сарын 08-ний өдрийн 06/2630 дугаартай албан бичигт дурдсаны дагуу Эрүүгийн хэрэг хянан	01.01- 12.08	100

	ажилласан байдал			нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохирогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна.	шийдвэрлэх ажиллагааны явцад Гаалийн ерөнхий газрыг хохирогч, 2. АТГ-ын 2024 оны 02 сарын 02-ний өдрийн 06/2223 дугаартай албан бичигт дурдсаны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гаалийн ерөнхий газрыг хохирогч, 3. АТГ-ын ЭХХШТХ-ийн 9.5-ын 4-т заасан хохирогчийн эрх, үүрэг хэрэгжүүлэх хууль ёсны төлөөлөгчөөр 2024.03.12-ны өдрийн №06/4488 албан бичгийн дагуу Гаалийн ерөнхий газрыг хохирогч, иргэний нэхэмжлэгч, 4. АТГ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд /№2302007650045/ ЭХХШТХ-ийн 9.5-ын 4-т заасан хохирогчийн эрх, үүрэг хэрэгжүүлэх хууль ёсны төлөөлөгч,		
3	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр		Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	Тайлант хугацаанд Хуулийн хэлтсийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй болно.	01.01-12.08	100
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр		Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана.	1.ЭХХШТХ-ийн 9.5-ын 4-т заасан хохирогчийн эрх, үүрэг хэрэгжүүлэх хууль ёсны төлөөлөгчөөр мөн хуулийн 8.1-ийн 4-т заасныг үндэслэн 4 тогтоосон байх тул ГЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, мэдүүлэг өгөх зэргээр ажилласан.	01.01-12.08	100

5	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл ээр		Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажилд оролцсон байна.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор ХЗДХЯ, Монголын цахим институт, Монгол улсын MNS ISO 31010:2016 стандарт, ҮТХороо зэрэг төрийн байгууллагын Байгууллагын эсдэлийг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийг судлаж тус нэгжийн дотоод эрсдэлийг ангилан, тогтоосон болно. Үүнд: 1. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгууллалтын эрсдэл, Албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэгт хамаарахгүй үүрэг даалгавар хүлээн авахгүй байх, өгсөн үүргийг ажлын ачлаалал болгохгүй цаг хугацаанд зэрэг гүйцэтгэх, 2. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл, Мэргэжлийн мэдлэг сул, ажил гүйцэтгэх чадваргүй байдал, ажлын хариуцлагагүй, ёс зүйгүй үйлдэл гаргахгүй 3. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл, 4. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл, мэдээллийг хугацаа хоцроох, буруу, алдаатай дамжуулсан зөрчил гаргахгүй байхыг олж харсан.	01.01-12.08	100
6	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Хэрэгжилт, гүйцэтгэл ээр, хувиар	-	1.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээсэн байна. 2.Удирдлагаас өгсөн үүрэг	Нэг.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээсэн байх чиглэлийн дагуу Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд тухай бүр санал авахаар дараах төслийг оруулах зөвлөгөөг өгч ажилласан болно. Үүнд: 1.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын төсөл 2.Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Журам батлах тухай" 680 дугаар	01.01-12.08	100

			даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажиллана.	тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Бараа устгах горим хэрэгжүүлэх журам”-ын төсөл, 3.“Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам”-ын төсөл 4.ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл, 5.“Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төсөл, 6.“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөл, Хоёр.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Монгол улсын иргэн Ж.Хүрэлбаатар нь Нидерланд Улсаас худалдан авсан Volvo маркийн ачааны автомашиныг Латви улсын хилээр нэвтрүүлэн ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч Монгол Улсад импортоор оруулж ирэх тал дээр туслалцаа хүссэний дагуу ГЕГ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсээс Монгол Улсаас БНПУ-д суугаа Элчин сайдын яаманд 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр дээрх асуудлаар и-мэйл илгээсэн байна. Монгол Улсаас БНПУ-д суугаа элчин сайд Б.Дорж нь 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Латви улсын Орлогын албаны Үндэсний гаалийн зөвлөлийн дарга Рэймонд Зукулстай уулзалт хийсэн тухай тэмдэглэлийг ирүүлсэн бөгөөд холбогдох баримтыг судалж, танилцуулга бэлтгэж удирдлагад танилцуулсан. Мөн түүнчлэн гаалийн улсын байцаагчдыг Соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлын		
--	--	--	---	---	--	--

				хүрээнд зохион байгуулах арга хэмжээний хүрээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүнд: “Ёс зүйн зөв чиг хандлагыг төлөвшүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт” зохион байгуулсан. Тухайлбал, 1.Чингис хаан нисэх онгоцны буудал дахь гаалийн газарт хөтөлбөрийн хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчил, Мөрдөгчийн мэдэгдэл” сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 17, 19-ний өдрүүдэд тус тус 3 цаг зохион байгуулсан. Сургалтад тус гаалийн газрын Захиргаан алба, Зөрчлийн алба, Санхүү, аж ахуйн алба, Эрсдэлийн алба, Хорио цээрийн алба, Бүрдүүлэлтийн алба, Хяналт шалгалтын албаны нийт 162 гаалийн улсын байцаагч, гаалийн улсын ахлах байцаагч-5, албаны дарга-5 албан хаагч нар хамрагдсан бөгөөд дээрх сургалтын хүрээнд Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад гаалийн холбогдох хууль тогтоомжуудаар сургалт орж, ярилцлага хийсэн. 2.Улаанбаатар хотын гаалийн газарт хөтөлбөрийн хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчил, Мөрдөгчийн мэдэгдэл” сургалтыг 2024.10.04-нд 07.30 цагаас 2 цаг 30 минутын хугацаанд зохион байгуулсан. Сургалтад газрын дарга 1, албаны дарга 5, гаалийн улсын ахлах байцаагч 15, гаалийн улсын байцаагч 110, нийт 131 албан хаагч хамрагдсан бөгөөд дээрх сургалтын хүрээнд Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай		
--	--	--	--	--	--	--

				хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль бусад гаалийн холбогдох хууль тогтоомжуудаар сургалт орж, АТГ-ын Мөрдөгчийн мэдэгдлийн талаар зохих ойлголт өгч, мэдэгдэлд дурдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариуг хүргүүлэх талаар ярилцлага хийсэн. 3.Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт хөтөлбөрийн хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчил, Мөрдөгчийн мэдэгдэл” сургалтыг 2024.11.08-ны өдрийн 09.00-10.30 цагт зохион байгуулсан. Сургалтад Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүсэд танхимаар болсон сургалтад тус гаалийн газрын дарга, Зөрчилтэй тэмцэх хэрэг бүртгэх алба, Захиргааны албаны дарга нар, Эрсдэлийн удирдлагын гаалийн улсын байцаагч 3, гаалийн улсын ахлах байцаагч 3, Захиргааны албаны гаалийн улсын байцаагч нар нийт 14 төрийн тусгай албан хаагч, 1 төрийн үйлчилгээний албан хаагч оролцсон бол цахимаар “Ди-Эйч-Эль” гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа 15, “Монгол шуудан-Нисэх” гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа 4, “Монгол Инфинити шуудан” дахь гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа 4, “Монгол шуудан-Шинэ нисэх” дэх гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа 4 албан хаагч нар цахимаар сургалтад хамрагдсан бөгөөд нийт 41 албан хаагч тус сургалтад хамрагдсан байна. Дээрх сургалтын хүрээнд Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,		
--	--	--	--	--	--	--

				Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль бусад гаалийн холбогдох хууль тогтоомжуудаар сургалт орж, АТГ-ын Мөрдөгчийн мэдэгдлийн талаар зохих ойлголт өгч, мэдэгдэлд дурдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариуг хүргүүлэх талаар ярилцлага хийсэн. 4.Цахимаар зарим харьяа гаалийн газар, хороонд хөтөлбөрийн хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчил, Мөрдөгчийн мэдэгдэл” сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад Шивээхүрэн дэх гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Завхан, Увс аймаг дахь гаалийн хороодын албан хаагч нар хамрагдсан бөгөөд Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад гаалийн холбогдох хууль тогтоомжуудаар танилцуулга хийж, харилцан ярилцлага хийсэн. Тайлангийн хугацаанд нийт 44 албан бичиг ирсэн ба үүнээс хариугүй 5, хариутай 39 албан бичгээс 28-д нь бичгээр хариу өгсөн ба, мөн үлдэх 10 албан бичигт утсаар хариу зөвлөгөө, мэдээлэл өгөх зэргээр шийдвэрлэж ажилласан. 28 албан бичиг явсан ба АТГ, Захиргааны хэргийн шүүх, Нийслэлийн прокурорын газар зэрэг төрийн		
--	--	--	--	---	--	--

					байгууллагууд -12, харьяа гаалийн газар хороонд -11, иргэн, аж ахуйн нэгжид -5 албан бичиг явуулсан байна. Хугацаа хэтэрсэн, хариу өгөөгүй албан бичиг байхгүй болно.		
7	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана.	Гаалийн улсын байцаагч П.Сүхбаатар нь 2024 он нийт ажлын 20 хоногийн өвчтэй, 1 сарын цалингүй чөлөөтэй байсан ба бусад хугацаан бүрэн ажилласан болно.	01.01-12.08	100
8	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Улсын Их Хурлын 2023 оны 60 дугаар тогтоолоор “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах” үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан Шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд оролцон.	01.01-12.08	100
9	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянасан, хэрэгжилтийг хангасан байх - Тайланд нотломжийг хавсаргасан байх	-	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах ажилд оролцсон байна.	Тайлант хугацаанд Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах ажилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. “Зарим төрийн тусгай албан албан тушаалд иргэнийг томилоход тавигдах шаардлага болон гаалийн улсын байцаагчаар томилох иргэнд тавигдах шаардлага”-ын төсөл, 2. Боршоо-Хандгайт боомтын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал бүхий ноот бичгийн төсөл, 3. Сайншанд дахь гаалийн газрын даргын албан үүргийг түр орлонгүйцэтгэгч Н.Батцэнгэлийн 2024 оны 1 дүгээр сард баталсан Б/01, Б/02, Б/03 тушаалуудыг хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцүүлэн	01.01-12.08	100

					хянаж, дараах зөвлөмжийг хүргүүлж зөвлөмж хүргүүлсэн. 4. Гашуунсухайт дахь гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Ганбаярын 2024 оны 1 дүгээр сард баталсан 2024 оны А/02, Б/03 дугаартай тушаалуудыг хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцүүлэн хянаж, дараах зөвлөмжийг хүргүүлж зөвлөмж хүргүүлсэн. 5. Орхон аймаг дахь гаалийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчдын сарын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Б/01 тушаалыг хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцүүлэн хянаж, дараах зөвлөмжийг хүргүүлж зөвлөмж хүргүүлсэн. 6. Гаалийн ерөнхий газар болон “Арш Технологи” ХХК-ийн хооронд хийсэн худалдах, худалдан авах гэрээ, 7. Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ 8. ГЕГ болон Голомт банкны хамтран ажиллах гэрээний төсөл, 9. “Глобал телеком инженеринг” ХХК-тай хийсэн ажил гүйцэтгэх гэрээ 10. Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө-2024.03.20-2024.12.12”-ний төсөл,		
10	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм,	Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ	-	1.Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ,	1 Гаалийн байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд АТГ-ын ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/4936 дугаартай “Журам хянасан тухай” албан бичиг ирсэн. Үүний дагуу ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан	01.01-12.08	100

журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	э, үнэлгээ хийсэн байх; -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.		үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл боловсруулах ажилд санал өгч оролцсон болно.		
---	---	--	---	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Анхан шатны мэдлэг олж авсан байна	Монгол бичгийн мэдлэгээ бие дааж уншиж судалан дээшлүүлсэн болно.	01.01-12.08	100
2	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	“Архивын тухай” хууль, “Монгол хэлний тухай” хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам”, Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичиг стандарт MNS5140:2021” зэрэг баримт бичгийг тус тус уншиж судалснаар албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ зохих түвшинд дээшлүүлсэн.	01.01-12.08	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН ХЭЛСТИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

П. Сүхбаатар /П.СҮХБААТАР /

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ П.СҮХБААТАРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”					
1.	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	60	10	70	62
2.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	60	10	70	60
3.	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	60	10	70	66
4.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	60	10	70	50
5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	60	10	70	63
6.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	61
7.	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	60	10	70	60
8.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	65
9.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	60	10	70	65
10.	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	60	10	70	65
11.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон	60	10	70	65

тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах				
Дундаж оноо:			70.0	62

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	14	14	8
2.	2025 оноос хос бичгээр албан хэрэгтэй хөтлөхтэй хрорглуулан Монгол бичиг бие даан сурах	14	14	10
Дундаж оноо:			14	9

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Асуудал шийдвэрлэх	7	7
3.	Хариуцлагатай байдал	7	7
4.	Дүн шинжилгээ хийх	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	5
Дундаж оноо:		7	6,6

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

№	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


№	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт орно)	70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	8

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	85,6
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		99

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:


Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 (Ч.Тамираа)
2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:


Гаалийн улсын байцаагч

 (П.Сүхбаатар)
..... (огноо)

Үнэлгээг хянасан:


Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

 (Г.Энхтайван)
12/20, 2024 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн
улсын ахлах байцаагч

 (Ө.Тэгшээ)
2024. 12. 10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга

 (Р.Отгонжаргал)
..... (огноо)